

БНТУ-ЫН ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН СУРГАЛТЫН ОРЧИН НӨХЦӨЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Балжиннямын Баянмөнх
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, докторант,
цагдаагийн ахмад

БНТурк улсын цагдаагийн байгууллагын үүсэл хөгжилт нь нэн эртнээс улбаатай ч анх 1845.04.10-нд тухайн үеийн нийслэл Стамбул хотын нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор ЦАГДАА /polis/ нэртэй байгууллагыг бий болгосон нь орчин үеийн Туркийн цагдаагийн байгууллагын үүсэл байжээ. Жил бүрийн 4 сарын 10-ны өдрийг Турк улсын Үндэсний цагдаагийн баяр болгон тэмдэглэсээр удахгүй 168 жилийн ой болох гэж байна.

Өнөөдөр Туркийн цагдаагийн байгууллагатай холбоотой хоёр гол хууль үйлчилж байгаа нь 1937 оны 6 дугаар сарын 04-ны өдөр батлагдсан "Цагдаагийн байгууллагын тухай хууль", нөгөөдөх нь 1934 оны 7 дугаар сарын 04-ны өдөр батлагдсан "Цагдаагийн эрх, үүргийн тухай хууль" гэсэн хуулиуд юм.

1909 онд Стамбулд анхны "Цагдаагийн сургууль" байгуулагдсан ба өдгөө тус улсын өнцөг булан бүрт нийт 24 ийм сургууль үйл ажиллагаагаа явуулж цагдаагийн байгууллагын бага бүрэлдэхүүнийг 2 жилийн хугацаагаар бэлтгэж байна.

1937 оны 11 дүгээр сарын 06-нд Анкара хотод цагдаагийн удирдах ажилтнуудыг бэлтгэх зорилгоор "Цагдаагийн институт" байгуулагдсан нь өнөөгийн Турк улсын Цагдаагийн Академийн үндэс юм.

Тухайн үеийн Засгийн газрын гаргасан шийдвэр, удирдамжийн дагуу Туркийн цагдаагийн академийг 1937 онд үндэсний цагдаагийн байгууллагад ажиллах боловсон хүчин бэлтгэх зорилгоор цагдаагийн дээд боловсрол олгох боловсролын байгууллага болгон зохион байгуулсан байна.

1953 оны 5 дугаар сарын 11-нд "Авто замын хөдөлгөөний тухай хууль" батлагдсанаар анхны замын цагдаа бий болсон бөгөөд дээрх хууль нь цаг үеийн шаардлагаар 1983 оны 10 дугаар сарын 13-нд нийгмийн хөгжилтэй уялдуулан дахин шинэчлэн баталсан байна.

БНТУ-ын Үндэсний цагдаагийн газар 1982 онд Хэв Журмын цагдаагийн газар, 1985 онд тусгай чиг үүргийн хэлтсүүдийг байгуулсан байна. Учир нь БНТ улсад жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх явдал их байдаг нь Хэв Журмын Цагдаагийн Газрын гүйцэтгэх үүргийн ач холбогдлыг улам нэмэгдүүлдэг байна.

"Цагдаагийн байгууллагын тухай хууль"-д зааснаар Турк улсын нийгмийн хэв журмыг хангах хүчийг ерөнхий болон тусгай коллук гэж ангилдаг байна. Коллук гэдэг нь нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үүрэгтэй, шаардлагатай үед хууль тогтоомжид заасан хүч хэрэглэх болон бусад эрхийг эдэлдэг байгууллагуудыг хэлдэг ба энэ нь маш өргөн хүрээтэй ойлголт юм. Үүнд цагдаа, жандармагийн байгууллагаас эхлээд гэрээт хамгаалалтын алба, тосгоны хамгаалагч гэх мэтчилэн нийгмийн хэв журмыг хамгаалах үүрэгтэй бусад бүх байгууллагуудыг хамааруулдаг байна.

БНТУ-ын Үндэсний цагдаагийн газар нь цагдаагийн алба хаагчдын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч ирсэн бөгөөд шинжлэх ухаан технологийн сүүлийн үеийн дэвшилтэд арга хэлбэр, техник технологид тулгуурласан сургалтын орчныг бүрдүүлж, мэргэшсэн цагдаагийн офицер, албан хаагчдыг бэлтгэн гаргахад онцгой анхаарч ирсэн байна. Үүний нэг илрэл нь сургалтын орчин нөхцөлийг дээд зэргээр бүрдүүлэхээр явуулж байгаа үйл ажиллагаанаас харж болно.

Өнөөдөр БНТУ-ын Үндэсний цагдаагийн академийг эрхэмсэг ноён Осман Элмастас удирдан сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ эрхэм академийнхаа сургалтын орчин нөхцлийг сайжруулах маш том төсөл боловсруулан ажиллаж байгаатай би өөрийн биеэр танилцах боломж олдсон юм.

Үндэсний цагдаагийн академийн барилга нь 1971 онд баригдсан бөгөөд үүнээс хойш өнөөг хүртэл шинээр 6 байгууламж барьж ашиглалтанд оруулсан байна.

Гэвч энэ нь өнөөгийн Туркийн үндэсний цагдаагийн академийн үйл ажиллагаанд хангалттай хэмжээнд сургалт явуулах нөхцөл боломж бүрдэж чадаагүй гэж үзсэний улмаас 2011 онд тус академийн удирдлага 5000 хүний даац бүхий барилга байгууламж шинээр барихаар төсөл хөтөлбөрийг БНТУ-ын Ерөнхий сайдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн байна.

БНТУ-ын Үндэсний цагдаагийн академийн нийт талбай 5 сая м² бөгөөд үүний 360,0 мянган м² талбайд сургалтын 18 барилга байгууламж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд үүнд 450 сая лир буюу 300 сая орчим долларын төсөв хөрөнгийг зарцуулахаар тусгасан байна.

Энэ нь тус академийн үйл ажиллагааг төрөөс нь бүрэн хэмжээгээр дэмжин ажилладагын нэг хэлбэр бөгөөд сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх, нөгөө талаар сургалтын таатай орчинг бүрдүүлэх нь тус академийн одоогийн удирдлагын тэргүүлэх бодлого болох нь анзаарагдсан.

БНТУ нь өөрөө ихээхэн өвөрмөц онцлогтой орон бөгөөд Исламын шашинтай, Европ Азийг холбосон дамжин өнгөрөх гүүр болдог, нөгөө талаар хил залгаа орших зарим улсуудын иргэний дайны байдалтай байгаатай холбогдуулан хил залгаа зарим бүс нутагт хэв журмын нөхцөл байдал хүндэрдэг, эмх замбараагүй байдал байнга үүсч байдаг ихээхэн онцлогтой орон юм.

Өнөөдөр Туркийн цагдаагийн академи нь 2001 оны 4 сарын 25-нд хүчин төгөлдөр болсон Цагдаагийн дээд боловсролын актын дагуу их сургуулийн статустай болсон бөгөөд Аюулгүй байдлын шинжлэх ухааны факультет, аюулгүй байдлын шинжлэх ухааны институт, цагдаагийн албан хаагчийн тусгай мэргэжлийн курс гэсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус академийн зорилго нь цагдаагийн офицер, бага болон ахлах цагдаагийн ажилтнуудыг аюулгүй байдлын тухай зохих мэдлэг олгож, бүх шатанд хууль сахиулах ажлыг гүйцэтгэх чадвартай болгон бэлтгэн гаргахад оршдог юм байна.

Туркийн цагдаагийн академи нь улсын сургууль бөгөөд төрөөс сонсогчдын бүтэн жилийн хэрэгцээний хүнс, хувцас хэрэглэл, байр, ном зэргээр хангаж суралцах аятай тохитой орчин бүрдүүлж өгдөг нь академийн үйл ажиллагааны нэг онцлог болжээ.

Аюулгүй байдлын шинжлэх ухааны факультет нь энэ сургуулийн болон цагдаагийн байгууллагын нүүр царайг олон улсын түвшинд илтгэдэг ба шинэ мянганд цагдаагийн боловсролын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулдаг бахархал нь болсон факультет болсон байна.

Тус факультет нь боловсролын шинэ тогтолцоог хөгжүүлж Харассмасын үйл ажиллагааны хүрээнд 4 жилийн сургалтын хөтөлбөрөөр сургалтаа явуулдаг. Тус академи нь 2003 онд Болонь конвенцид нэгдсэн ба Туркийн засгийн газрын шинэчлэлийн хүрээнд бусад нийтлэг салбарт их дээд боловсрол олгодог болсон байна.

Аюулгүй байдлын шинжлэх ухааны факультет нь Европын Холбоонд мөрддөг кредитийн системийг хэрэгжүүлдэг ба эндээс төгсөн гарагчдын дипломыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг нь академийн бас нэг онцлог юм.

Туркийн цагдаагийн академи нь гадаадын олон орны цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг, гадаад харилцаа маш сайн хөгжсөн сургууль бөгөөд Аюулгүй байдлын шинжлэх ухааны факультетад гадаадын олон орноос залуус ирж суралцдаг бөгөөд тэднийг тэтгэлэгт

хөтөлбөрт хамруулан сурах боломжоор хангадаг төдийгүй турк сонсогчдын нэгэн хүнс, хувцас хэрэглэл, байр, номоор үнэ төлбөргүй хангадаг байна.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, БНТУ-ын Үндэсний цагдаагийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тус академид нийт 42 сонсогч оюутан суралцаж төгссөн бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсаас нийт 26 хүн суралцаж байгаагаас докторантурт 3, магистрантурт 3, бакалаврын сургалтанд 20 сонсогч суралцаж байна.

Түүгээр ч барахгүй Туркийн цагдаагийн академи нь бусад их дээд сургуульд сурдаг оюутнуудыг үндэсний цагдаагийн байгууллагын нийтлэг шаардлагад нийцүүлэн давтан сургалтанд хамруулдаг бөгөөд үндэсний цагдаагийн байгууллагын нарийн мэргэжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн түргэвчилсэн сургалт явуулдаг байна. Эндээс төгсөгчид тангараг өргөж туслах комиссарын үүргийг цагдаагийн байгууллагуудад гүйцэтгэж байна.

2001 онд Их дээд боловсролын 46-р актын дагуу 2 жилийн хугацаатай дипломын боловсрол олгох сургалт, бакалавраас өмнөх түвшиний сургалтыг явуулж эхэлсэн бөгөөд үндэсний цагдаагийн байгууллагад боловсон хүчин бэлтгэх эрхтэй болсон байна.

Мөн дипломын дараах боловсрол олгох сургалт явуулах бүрэн эрхтэй болсны зэрэгцээ их сургуулийн өмнөө тавьсан зорилгын хүрээнд олон нийтэд зориулж ном, сэтгүүл хэвлэж судалгаа хийж, мөн судалгаа хийлгэдэг цөм болсон байна.

Сүүлийн үед Туркийн цагдаагийн академи нь Туркын аюулгүй байдлын тухай шинжлэх ухааны бүтээл гаргаж ажиллахаар чармайж байгаа бөгөөд Туркийн үндэсний эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ажилладаг байна.

Туркийн цагдаагийн академийн сургалт нь 1 ангидаа 20-25 сонсогч бүлэглэн суралцдаг лекцийн хэлбэрээр орох тохиолдолд 45-60 сонсогч нэг дор танхимд байрлан суралцана. Гэхдээ эрэгтэй, эмэгтэй сонсогчдын сурах орчин, байрлах байр нь тусдаа байдаг нь тэдний шашны зан үйлтэй салшгүй холбоотой юм.

Турк сонсогч нар хичээлээс гадуур бусад бие бялдараа хөгжүүлэх, биен тамир, спортоор хичээллэх, биеэ чийрэгжүүлэх орчин нөхцөл, боломжийг дээд зэргээр хангасан байна. Ганцхан жишээ хэлэхэд Туркийн цагдаагийн академийн спорт комплексийн нэг болох усан сан байна.

Тус усан сан нь үндсэн ба туслах гэсэн 2 хэсгээс бүрдэж байгаа бөгөөд үндсэн усан санд уралдааны 8 замтай, усан сангийн хажууд үзэгчдийн 6 эгнээ суудалтай, доороо сонсогчдын хувцас солих өрөө, душ байрласан байх бөгөөд хамгийн сонирхолтой нь сонсогчид усан санд орж үйлчлүүлэхдээ халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор эмтэй усанд хөлөө дүрж усан сан руу ордог нь элдэв өвчин эмгэгээс сэргийлэх чухал ач холбогдолтой үйлдэл байдаг байна.

Өнөөдөр Туркийн цагдаагийн академи нь 168 жилийн түүхийн хөгжлийн үед олж авсан туршлага дээрээ үндэслэн ирээдүйн зорилгоо биелүүлэхийн тулд байнга зорилго тавин шамдаж байгаа нь өнөөдрийн үйл ажиллагаанаас тодорхой харж болох бөгөөд бид ч тэдний тэдний сургалтын үйл ажиллагааны орчин нөхцлийг бүрдүүлсэн байдлаас ихээхэн туршлага судалж, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглавал илүү үр дүнтэй байх болно.